



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/09

Онги

Улсын нөөцөөс хямдруулан олгосон
өвс тэжээлийг малчин болон мал бүхий
өрхөд хуваарилан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 461 дүгээр тогтоол, Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/15 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан улсын нөөцөөс 50 хувиар хямдруулан олгосон өвс тэжээлийг Эрдэнэдалай сумаас татах тээвэр, шатахууны зардал, ажилчдын хөлсөд зарцуулах зардлыг улсын нөөцөөс тогтоон олгосон үнийн дүн дээр нэмж сумын малчин, мал бүхий өрхөд хуваарилан өгөх өвс тэжээлийн үнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хямдруулан олгох өвс тэжээлийг малчин болон мал бүхий өрхөд олгох хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Хямдруулсан өвс, тэжээлийн үнийг 100081255407 тоот дансанд төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг нярав, сан хариуцсан нягтлан бодогч болон санхүү албаны дарга нарт үүрэг болгосугай.

4. Өвс тэжээлийг хуваарийн дагуу малчдад олгох ажлыг шуурхай зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА

Сумын Засаг даргын 2023 оны 01
дүгээр сарын 01-ны өдрийн А/09
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгосон өвс
тэжээлийн үнэ дээр нэмж тогтоосон үнэ

№	Өвс тэжээлийн үнэ	Улсын нөөцөөс 50 хувиар хямдруулсан үнэ	Тээврийн болон бусад зардлыг нэмж тогтоосон үнэ	Улсын нөөцөөс хуваарилагдан ирсэн нийт өвс тэжээл
1	Өвс /боодол/	5,375	7,000	1000
2	Тэжээл /25кг/	9,375	12,000	437
3	Тэжээл /40кг/	14,995	17,000	625

Сумын Засаг даргын 2023 оны 01
дүгээр сарын 20-ны өдрийн А.109
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгосон өвс тэжээлийн хуваарь

№	Сумын өрх	Өвс /боодол/	Тэжээл /25кг/	Тэжээл /40кг/	Тайлбар
1	Малчин өрх	2 боодол	1 тэжээл	1 тэжээл	430 өрхөд олгоно
2	Мал бүхий өрх	1 боодол	-	1 тэжээл	96 өрхөд олгоно
3	Агнуурийн бүс нутагт биотехникийн арга хэмжээ	44 боодол	-	-	Биотехникийн арга хэмжээнд зарцуулна
4	200-с доош малтай малчин өрх	-	-	1 тэжээл	99 малчин өрхөд олгоно
	Нийт малчин болон мал бүхий өрх 526	1000	437	625	